



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 01 дугаар сарын 30

№ 01/03 ДУА -2018/137/СТА -743

Мандалговь хот

Г

Т

Төлбөр барагдуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Сум дундын эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар цалингүй чөлөө авсан албан хаагчдад цалинг ажилласнаар тооцон олгож **131,316.00** /Нэг зуун гучин нэгэн мянга гурван зуун арван зургаан/ төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь тухайн үед Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2006 оны 06 сарын 25 ны өдрийн 171/111 тоот тушаалтын хавсралтын 4.2-т /... Ажлын цагийн тооцоог үндэслэн цалин хөлсний тооцоог хийх ..., Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2.а-д /Бүх шатны төсөв захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжсээ тогтоосон бусад шийдвэрлиг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-д /Бусад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолжс олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. **131,316.00** /Нэг зуун гучин нэгэн мянга гурван зуун арван зургаан/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Сум дундын эмнэлгийн төсвийн шууд захирагч Д.Батцэцэг, нягтлан бодогч У.Хандсүрэн нарт хариуцуулав.


АКТЫГ


ТОГТООСОН¹:

АУДИТОР:  И.ЮУН-ЭРДЭНЭ

4817144213
ЗЮА00-0 9033475

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ:  Д.БАТЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ:  У.ХАНДСҮРЭН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.